



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7 дахь заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 5 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИЛГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сөри/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хан Хиу Ву Han Хиуви	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	ГЭ0001863	Бөөрний мэс засал судлал	Эмчлэх	2018-01-20 2018-01-23 /3 хоног/
2.	Нагасэ Цүёши Nagase Tsuyoshi	Япон Улс	"Ачтан-Элит" ХХК-ийн "Ачтан" эмнэлэг	ГЭ0001864	Үе бүтээх, солих мэс засал судлал	Эмчлэх	2018-02-09 2018-02-12 /4 хоног/
3.	Жэ Вон Жу Jo Jaen Won	Бүгд Найрамдах Солонгос Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001865	Элэг шилжүүлэн суулгах мэс засал судлал	Эмчлэх	2018-01-28 2018-02-02 /6 хоног/
4.	Ким Жонг Ман Kim Jong Man	Бүгд Найрамдах Солонгос Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001866	Элэг шилжүүлэн суулгах мэс засал судлал	Эмчлэх	2018-01-28 2018-02-02 /6 хоног/
5.	Жастин Сангвүүк Ко Ko Justin Sangwook	Бүгд Найрамдах Солонгос Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001867	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2018-01-28 2018-02-02 /6 хоног/

Эрүүл-мэндийн гайд
 2018 оны 01 сарын 19 ны өдөр
 УИЧ дугаар тушаалын хавср